БАТЛАВ.
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Н.УУГАНБАЯР

2022 оны 01 дүгээр сарын ...өдөр

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 01 дүгээр сарын 17

Улаанбаатар хот

| № | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 1 | 4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох | Жилдээ | Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлсэн нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн тоо, томилсон байдал | - | Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | | 2 | Сул орон тоо гарсан тохиолдолд зохих журмын дагуу нөхөх арга хэмжээг зохион байгуулах | Жилдээ | Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна. | - | |
| | | 3 | Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлэх | Жилдээ | Нөөцийн бүртгэлийг Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд оруулсан байна. | - | |
| 2 | 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт | 1 | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн албан тушаалд туршилтаар болон | Жилдээ | Шалгуурыг үндэслэн албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан тухайн албан тушаалд нэр дэвшүүлж, | - | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | | жинхэлж томилох, дэвшүүлэх | | томилно. | | |
| 3 | 4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 1 | Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /erp.e-mongolia/-ийг байгууллагад нэвтрүүлэх | 1 дүгээр улиралд | Төв, орон нутгийн нэгжийн дарга, албан хаагчдыг бүртгэсэн, дотоод үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна. | - | Захиргаа, удирдлагын газрын дарга, Мэдээллийн технологийн хэлтэс |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 4 | 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | 1 | Гадаадын иргэн, харьяатын газраас олгодог лавлагаа, тодорхойлолт, зөвшөөрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулах, цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Жилдээ | e-mongolia цахим сүлжээнд байгууллагаас олгодог лавлагаа, тодорхойлолт, зөвшөөрлийн үйлчилгээг холбосон байна. | - | Мэдээллийн технологийн хэлтсийн дарга, ерөнхий инженер |
| | | 2 | Байгууллагын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ болон дотоод үйл ажиллагааг цахимжуулах, нэгдсэн сүлжээтэй болгох | Жилдээ | “Гэрэгэ системс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагааны нэгдсэн системтэй болсон байна | - | |
| 5 | 4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | 1 | Иргэдээс өргөдөл, гомдол гаргах сувгийн талаарх мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулах, өргөдөл, гомдлыг цахимаар гаргах нөхцөл, боломжоор хангах | Жилдээ | Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын хэлбэр, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | - | Өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн |
| | | 2 | Байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гарсан энэ төрлийн мэдээ, мэдээллийн мөрөөр дотоод, хяналт шалгалт хийх, үр дүнг тооцох, шалтгаан нөхцөлийг арилгах | Жилдээ | Олон нийтэд мэдээ, мэдээллийг шуурхай, үнэн зөв хүргэх боломжийг бүрдүүлнэ. | - | Олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн |
| 6 | 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, | 1 | 2021 оны хэрэглэгчийн үнэлгээнээс гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх | Жилдээ | Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулсан, хэрэгжилтийг хангасан байна. | - | Дотоод ажил, судалгаа хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг сайжруулах | 2 | 2022 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх | 4 дүгээр улиралд | Хэрэглэгчийн үнэлгээний дүн, санал, зөвлөмжийг үндэслэн төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлнэ. | 10.0 сая | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн |
| Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 7 | 4.1.3.1.улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | 1 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлж, санхүүгийн ил тод байдлыг хангаж | Жилдээ | www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд, албан хаагчдад цахимаар болон мэдээллийн самбарт нээлттэй байршуулж, мэдээлэл хүргэсэн байна. | - | Санхүүгийн хэлтсийн дарга, төсвийн ахлах мэргэжилтэн |
| 8 | 4.1.3.2.төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Нийцлийн болон санхүүгийн аудит хийж, төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж хэрэгжилтийг ханган ажиллах | Жилдээ | Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашиг сайжирсан байна. | - | Дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн |
| 9 | 4.1.3.10.төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах | 1 | Байгууллагын шилэн дансны цахим хуудаст төрийн аудитын байгууллага болон бусад байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтын дүгнэлт, зөвлөмж, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг хуулийн хугацаанд олон нийтэд ил тод мэдээлэх | Жилдээ | Байршуулсан мэдээллийн тоо | - | Санхүүгийн хэлтсийн дарга, төсвийн ахлах мэргэжилтэн |
| Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 10 | 4.1.4.3.худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох | 1 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах | Жилдээ | Зохион байгуулсан тендерийн тоо, гүйцэтгэл | - | Хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн |
| | | 2 | Худалдан авах ажиллагааны А-3 гэрчилгээтэй албан хаагчдын тоог нэмэгдүүлэх | Жилдээ | Төвийн зарим нэгжийн дарга, албан хаагчдыг сургалтад хамруулж, эрхтэй албан хаагчдын тоог нэмэгдүүлсэн байна. | 675.0 м/т | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | |
| 11 | 4.1.10.1.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 1 | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Жилдээ | Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналт сайжирна. | - | Орон нутаг дахь газрын салбар эрх бүхий албан тушаалтан |
| | | 2 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт шалгалтын чиг үүрэг бүхий албан тушаалтнуудыг “мэдэгдэл, тайлбар” гаргуулж, цахим системд бүртгэх | Тухай бүр | Хяналтын улсын байцаагч нарыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын өмнө хууль тогтоомжийн дагуу “мэдэгдэл, тайлбар” гаргуулж, бүртгэж хэвшүүлсэн байна. | - | Төв, орон нутаг дахь газрын салбар эрх бүхий албан тушаалтан |
| 12 | 4.1.10.4.авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах | 1 | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах албан хаагчийг чадавхжуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах | 1, 3 улиралд | Авлигын эсрэг сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | - | Сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ДАВААНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН В.ШООВДОР